

БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Си Эм Кэй Ай ХХК нь Монгол улсын 9019046024 улсын бүртгэлийн дугаартай гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжийн гэрчилгээ эзэмшдэг. Хайлуур жоншны хүдэр баяжуулах эрхийг 2013 онд авсан бөгөөд 2014 оноос баяжуулах үйлдвэрийн угсралтын ажлыг эхлүүлсэн.

Монгол улсын газрын тухай хууль, Хэнтий аймгийн Бор өндөр сумын засаг даргын 2019 оны 09-р сарын 21-ний А/189/2018 тоот шийдвэрийн дагуу 25 га талбайг 5 жилийн хугацаатай ашиглуулахаар олгосон.

Баяжуулах үйлдвэрийн байршил

Си Эм Кэй Ай ХХК-ийн жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16”, “Хүдрийн биет-16-1” нэртэй хайлуур жоншны ордын MV-004153, MV-016772 тоот дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад байрлана.

Улаанбаатар хотоос зүүн урагш 310 км-т, Хэнтий аймгийн төвөөс зүүн урагш 140 км, Бор-Өндөр сумаас баруун хойш 3.5 км-т орших ба ойр орчимд нь Бор-Өндөрийн хайлуур жоншны хүдрийн зангилаанд хамаарагдах Бор-Өндөр, Адаг, Зүүн цагаан дэл, Бор толгой Айраг зэрэг орд газрууд байдаг бөгөөд ашигт малтмалын хувьд “Хүдрийн биет-16” орд нь тус ордуудыг төлөөлөх чадвартай юм.



Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил

Баяжуулах үйлдвэрийн орчны төлөв байдал

Уул зүй

Баяжуулах үйлдвэр байрлаж буй талбайн орчин бүхэлдээ 1280-1400м-ийн өндөрлөгтэй уул толгод, ухаа гүвээ тэдгээрийн хоорондох тэвш маягийн хөндий тал зонхилсон тал хээрийн бүсэд хамаарагдана.

Талбайн хэмжээнд хамгийн өндөрлөг цэг нь 1447.56 м өндөртэй Их бор овоо, хамгийн нам дор цэг нь 1271.1 м өндөрлөг бүхий Бор-Өндрийн булгийн хөндий юм. Усан сүлжээ муу хөгжсөн, талбай түүний дүүргийн хэмжээнд байнгын устай гол, горхи ховор. Ордоос зүүн урагш шорвог устай жижиг нуурууд байх ба сүүлийн жилүүдэд зөвхөн зуны улиралд хур бороо ихтэй үед усаар дүүргэгдэх боловч дороо хатаж ширгэдэг болсон. Ордоос 5-6 км-ийн зайд орших, 2700-2900 л/ц ундаргатай гар ба гүний худгуудаас нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээгээ хангадаг.

Дэд бүтэц

Баяжуулах үйлдвэр нь манай орны эдийн засгийн зүүн бүсийн дэд бүтэц эрчимтэй хөгжиж буй нутагт багтдаг. Хамгийн ойрхон томоохон суурин газар нь 10 мянга орчим хүн амтай Бор-Өндөр тосгон бөгөөд эмнэлэг сургууль, төмөр зам, хувийн хэвшлийн жижиг үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүд ба үүрэн телефон, шатахуун түгээх станцууд тогтмол ажиллагаа явуулдаг.

Эдийн засгийн дэд бүтэц харьцангуй сайн төвлөрсөн цахилгаан эрчим хүчний 110кВ шугамаас гадна төмөр замын сүлжээтэй мөн 2022 онд ашиглалтанд орох Далан жаргалан-Бор өндөр чиглэлийн хатуу хучилттай авто замаар Улаанбаатар-Замын үүд чиглэлэийн төв замтай холбогдно.

Уур амьсгал

Тус баяжуулах үйлдвэр байрлаж байгаа орчны уур амьсгалын хувьд эрс тэс, улирлын болон өдөр, шөнийн температур их зөрүүтэй ажиглагддаг. Уур амьсгал нь хоногийн болон улирлын температур, агаарын даралт ихээр хэлбэлздэг, эх газрын эрс тэс бөгөөд өвөл нь урт, хүйтэн -38 хэм, зун нь +40 хэм хүрдэг. Хур тунадасны жилийн дундаж хэмжээ Бор-Өндөр тосгоны цаг уурын станцын мэдээгээр 244мм орчим байна.

Анхны цас 10-р сарын дундуур орох ба 4-р сарын төгсгөл болтол цас бүрэн хайлж дуусахгүй. Салхины хурд тогтмол 4.4-10 м/сек байдаг боловч өвөл, хаврын цагт зарим үед 28м/сек хүрдэг.

Хөрс ургамал амьтаны аймаг

Хөрс нь өөрийн бүтэц, тархалт ба зузаанаараа харилцан адилгүй, хээр талын хүрэн, хүрэвтэр, бор шороон хөрс зонхилох бөгөөд нам дор газартаа цайвар шаргал, хужирлаг, өндөрлөг газартаа уулын хүрэн, хүрэвтэр өнгийн хөрс ялгагдана. Цайвар болон бор хүрэн, цайвар шаргал хөрс нь гол-нуурын гаралтай шавар, шавранцраас тогтоно. Хөрсний үений зузаан нь 0.1 м-ээс 0.4 м-ийн хооронд хэлбэлзэнэ.

Тус нутгийн хэмжээнд ургамлын тархалт ерөнхийдөө сийрэг, өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн. Ургамалын бүрхэвчийг бүрэлдүүлэгч гол ургамал нь шивээ, хялгана, хазаар, агь, хөмүүл, зангуу, шарилж зэрэг болно.

Ан, амьтнаас элбэг тохиолдох нь үнэг, хярс, дорго, мануул, цагаан оготно, олби оготно, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Хамгийн элбэг нь цагаан зээрийн сүрэг юм.

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн технологийн горим, төлөвлөлт

2022 онд тус баяжуулах үйлдвэр нь 1-р улиралд технологийн жигдрүүлэлт, цахилгаан хангамжийн жигдрүүлэлт, дулаан хангамжийн оновчлолыг хийж гүйцэтгэнэ. Энэ онд нийт 50 мянган тонн хүдэр баяжуулж 12 мянган тонн фф-97 маркийн баяжмал гаргана. Түүхий эд болох жоншны хүдрийг бусад уурхайгаас мөн өөрийн олборлолтоос нийлүүлэхээр гэрээ байгуулсан.

Хүснэгт 1. Баяжуулах үйлдвэрийн 2022 онд ажиллах төлөвлөлт

| Үйлдвэрлэл | Х/нэгж | Сарууд | | | | Нийт |
|----------------------------|--------|--------|------|------|-------|------|
| | | 5-7 | 7-9 | 9-10 | 11-12 | |
| Хүдэр боловсруулалт | Мян.тн | 12.5 | 12.5 | 12.5 | 12.5 | 50 |
| Хайлуур жоншны баяжмал | Мян.тн | 3 | 3 | 3 | 3 | 12 |
| Гадаад борлуулалт /гадаад/ | Мян.тн | 3 | 3 | 3 | 3 | 12 |

Хөндлөнгийн байгууллагаар хийлгэх технологийн хяналт сорьцлолт

Баяжуулах, боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлагын хүрээнд технологийн хяналт сорьцлолтын ажлыг жилд 1-ээс доошгүй удаа хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлсэн байх ёстой байдаг бөгөөд 2022 онд манай баяжуулах үйлдвэр нь “Могоул Минерал Ресурс” ХХК-аар 11-р сард уг ажлыг хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан.

Жонш баяжуулах үйлдвэрийн технологийн горим

Баяжуулах үйлдвэр нь уурхайгаас ирсэн хүдрийг буулгах, жигдрүүлэх талбайд хүлээн авна, хүдэр бэлтгэх хэсэг нь 3 шатны бутлуур, 1 шатны шигшүүрээр дамжуулан -30мм ширхэглэлтэй болтол бутална. Бутлагдсан хүдрийг нөөцийн агуулахад туузан дамжуургаар агуулна. Хүдэр нунтаглалын хэсэг нь 2 шатны нунтаглалт 2 шатны ангилагчтай бөгөөд эхний шатны ангилалтыг мушгиа ангилагчаар явуулах бол 2-р шатны ангилалтыг гидроциклон ангилагчаар явуулна.

Нунтаглагдсан хүдрийн хатуулгийн хэмжээ 35% байх бөгөөд флотацид хэрэглэгдэх 3 төрлийн бодистой холигч танканд холих бөгөөд эндээс соролтын хүчээр

үндсэн болон хяналтын, цэвэрлэгээний флотацид орж эцсийн баямал гарна. Усгүйжүүлэх хэсэг нь төвийн хөтлөгчтэй өтгөрүүлэгч, вакуум соролтын усгүйжүүлэх фильтрээс бүрдэх бөгөөд 12-14% чийглэгтэй баяжмал 2тонн даац бүхий уутанд савлагдна.

Үйлдвэрийн ерөнхий үзүүлэлт

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТООН УТГА |
|----|----------------------------------|-------------------------------|
| 1 | Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал | 150 мян.тн/жил |
| | | 540тн/хоног |
| | | 22.5тн/цаг |
| 2 | Жилд ажиллах хоног | 278 |
| 3 | Жилд ажиллах цаг | 6672 |
| 4 | Бутлагдсан хүдрийн ширхэглэл | -30мм |
| 5 | Анхдагч хүдэр дэх жоншны агуулга | 25-35% |
| 6 | Хүдэр бэлтгэх хэсэг | 3 шатны бутлалт |
| | | 1 шатны шигшилт |
| | | 2 шатны нунтаглалт |
| | | 2 шатны ангилалт |
| 7 | Хүдэр баяжуулах хэсэг | 1 шатны үндсэн флотаци |
| | | 3 шатны хяналтын флотаци |
| | | 7 шатны цэвэрлэгээний флотаци |
| 8 | Усгүйжүүлэх хэсэг | Төвийн хөтлөхтэй өтгөрүүлэгч |
| | | Дискэн вакуум фильтр |
| 10 | Туслах хэсэг | Урвалж найруулах чан |
| | | Хаягдлын байгууламж |

1.3. Баяжуулах үйлдвэрийн химийн урвалжийн хэрэглээ

Үйлдвэрт хэрэглэх үндсэн урвалжуудын болон ган бөмбөлөгийн зарцуулалтын хэмжээг технологийн туршилтын үр дүнд болон хүдрийн хатуулагт тулгуурлан тогтоосон болно.

Хүснэгт 2. Баяжуулах үйлдвэрт хэрэглэх урвалжийн хэмжээ

| Үзүүлэлтүүд | Нэгж зарцуулалт, гр/тн | Хэмжих нэгж | 1-р жил | 2-р жил | 3-р жил | 4-р жил | 5-р жил | Нийт |
|--------------------------|------------------------|-------------|---------|---------|---------|---------|---------|------|
| Баяжуулах хүдрийн хэмжээ | - | мян.тн | 150.0 | 150.0 | 150.0 | 150.0 | 150.0 | 750 |
| Тосны хүчил | 800 | тн | 120.0 | 120.0 | 120.0 | 120.0 | 120.0 | 600 |
| Техникийн сод | 440 | тн | 66.0 | 66.0 | 66.0 | 66.0 | 66.0 | 330 |
| Шингэн шил | 520 | тн | 78.0 | 78.0 | 78.0 | 78.0 | 78.0 | 390 |
| Хөнгөнцагааны сульфат | 1000 | тн | 150.0 | 150.0 | 150.0 | 150.0 | 150.0 | 750 |

Техникийн сод (Na_2CO_3)

Техникийн сод нь шүлтлэг орчныг тохируулагч, шаардлагатай рН бүрдүүлдэг, усанд сайн уусдаг. 1%-ийн содын уусмал рН=11 хүртэл орчинг бүрдүүлнэ. 5%-ийн содын уусмалыг тээрэмд өгнө. Сод болон шингэн шилний шүлтлэг урвалжийг флотацид хэрэглэснээр хөвүүлэн баяжуулах процесс нь шүлтлэг орчинд явагдана. Шүлтлэг орчинд хөөсрөлт сайн бүрэлддэг.

Хүснэгт 3. Техникийн сод (Na_2CO_3)-ийн норм, шаардлага

| № | Үзүүлэлтүүд | Норм | |
|---|---|-----------------------------|---------|
| | | Сорт 1 | Сорт 2 |
| 1 | Гадаад байдал | Нунтаг цагаан өнгөтэй бодис | |
| 2 | Na_2CO_3 агуулагдах хэмжээ, %, багагүй | 99.2 | 99.0 |
| 3 | Хлоридын агуулга, %, ихгүй | 0.5 | 0.8 |
| 4 | Fe_2O_3 тооцсон төмрийн агуулга, %, ихгүй | 0.003 | 0.008 |
| 5 | Усанд үл уусах бодис, %, ихгүй | 0.04 | 0.08 |
| 6 | Na_2SO_3 тооцсон сульфатын агуулга, % ихгүй | 0.05 | Нормгүй |
| 7 | Хувийн жин, тн/м ³ | 2.48 | 2.48 |

Шингэн шил (Na_2SiO_3)

Шингэн шил нь бага зэрэг ногоон, шар туяатай тунгалаг хатуу бодис юм. Натрийн силикатыг үйлдвэрийн нөхцөлд 1300-1500⁰С температурт элсэн чулууг хайлуулж гарган авдаг. Задгай саванд байгаа шингэн шилний уусмал нь тогтворжилт муутай байдаг. Уусмалын концентраци нь 5%-иас хэтрэх ёсгүй. Шингэн шил нь хөвүүлэн баяжуулалтанд кварц, силикат болон хоосон чулуулгийг дарах зориулалттай хэрэглэгддэг.

Хүснэгт 4. Шингэн шил буюу силикат натрийн шаардлага

| № | Үзүүлэлт | Шаардагдах норм | |
|---|----------|-----------------|---------------|
| | | Содын | Сульфат содын |

| 1 | Гадаад хэлбэр | Жигд, тунгалаг, хэлбэр дүрсгүй | |
|---|---|--------------------------------|------------------------|
| | | Ногоовтор ба цэнхэр туяатай | Хар ногоон ба хүрэн |
| 2 | SiO ₂ -н агуулга,% -аас игүй | 70.8-76.2 | 69.7-72.4 |
| 3 | Кальцийн исэл,% ихгүй | 0.4 | 0.5 |
| 4 | Хүхрийн ангидрид,% ихгүй | 0.3 | 1.25 |
| 5 | Натрийн исэл,% | 22.5-27.9 | 24.9-27.5 |
| 6 | Силикатын модуль | 2.61-3.5 | 2.61-3.0 |
| 7 | Хувийн жин,тн/м ³ | 2.7 | 2.7 |

Тосны хүчил (C₁₇H₃₃COOH)

Тосны хүчлийг найруулахдаа холих танкны 2/3–т ус хийж холигч сэнсийг эргүүлж халуун уураар халаахын зэрэгцээ 240 кг буюу 6 уут содыг хийж 2 цагийн турш уусгалтыг явуулна. Уусмалыг 70-80⁰С хүртэл халаана. Содыг уусгасны дараа 1.4 м³ тосны хүчлийг танканд хийнэ. Холих танкыг усаар дүүргэн 70-80⁰С –ийн температурт 2-3 цагийн хугацаагаар уусгах ажиллагаа явуулна. Үүний дараа уусмалаас дээж авч концентрацийг тодорхойлно. Уусмалын концентраци 1.5% байна.

Хөнгөнцагааны сульфат (Al₂(SO₄)₃*7H₂O)_n

Хөнгөнцагааны сульфат нь зунгааралдсан шинж чанартай, хурц үнэртэй, шаравтар туяатай тунгалаг бодис юм.

Булинга дахь тунадасыг барьцалдуулах идэвх сайтай бодис юм. Өтгөрүүлэх процесст идэвх сайтай.

1.4. Баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж

Хүснэгт 5. Тоног төхөөрөмжийн насжилт

| № | Тоног төхөөрөмжийн нэр | Марк | Ашигладганд орсон он | Ашиглалтын хугацаа |
|----|------------------------|--------------|----------------------|--------------------|
| 1 | Чичиргээт тэжээгүүр | Y47100200 | 2015 | 5 |
| 2 | Хацарт бутлуур | PE600x900 | 2015 | 5 |
| 3 | Туузан дамжуулагч | BK-800 | 2015 | 5 |
| 4 | Конусан бутлуур | PFL-1750A | 2015 | 5 |
| 5 | Туузан дамжуулагч | BK-1000 | 2015 | 5 |
| 6 | Чичиргээт шигшүүр | SZZ22142 | 2015 | 5 |
| 7 | Чичиргээт тэжээгүүр | 600x600 | 2015 | 5 |
| 8 | Гидроциклон | XC-II-Ф350 | 2015 | 5 |
| 9 | Бөмбөлөгт тээрэм | Ф2400x6000 | 2015 | 5 |
| 10 | Мушгиа ангилуур | BJ-3000x3000 | 2015 | 5 |
| 11 | Бөмбөлөгт тээрэм | Ф2100x4500 | 2015 | 5 |
| 12 | Флотомашин | SF-1.2 | 2015 | 5 |
| 13 | Флотомашин | SF-2.8 | 2015 | 5 |
| 14 | Булингийн насос | 125 | 2015 | 5 |
| 15 | Булингийн насос | 30 | 2015 | 5 |

| | | | | |
|----|---------------------|-----------|------|---|
| 16 | Баяжмал өтгөрүүлэгч | NZ-15 | 2015 | 5 |
| 17 | Баяжмалын шүүлтүүр | GP48-4 | 2015 | 5 |
| 18 | Хатаагуур | SZL4-1.25 | 2017 | 3 |
| 19 | Өргөгч кран | LDA-3 | 2014 | 6 |
| 20 | Цахилгаан кран | LDA-10 | 2014 | 6 |
| 21 | Цахилгаан кран | LDA-5 | 2014 | 6 |

1.5. Төслийн барилга байгууламж, дэд бүтэц

1.5.1. Төслийн усан хангамж

Баяжуулах үйлдвэрийн усан хангамж

Үйлдвэрт хэрэглэх усыг зориулалтаар нь технологийн, техникийн, унд-ахуйн ус, бусад хэрэглээний ус гэж ялгаж тооцоолон, үйлдвэрт нийтэд нь шаардлагатай усны хэмжээг тооцоолсон болно. Үйлдвэрийн технологийн усны хэрэгцээ цагт дунджаар 102.4 м³ түүхий ус шаардлагатайг үйлдвэрийн усны балансын тооцоогоор тогтоосон ба баяжуулах үйлдвэр нь ашиглагдсан усныхаа **77.8%**-ийг эргүүлэн ашиглах ба үйлдвэрийн цэвэр усны хэрэгцээ хоногт 431.66 м³ байна. Уг хэрэгцээг төслийн талбайд байрлах 10.0 л/с, 2.0 л/с, 2.0 л/с ундарга бүхий 3 худгаас хангана.

Хүснэгт 6. Технологийн усны хэрэглээ

| № | Үзүүлэлт | Норм | Баяжуулах бүтээгдэхүүний хэмжээ, тн | | Нийт ашиглах усны хэмжээ, м ³ | | Эргэлтийн системээр дахин ашиглах усны хэмжээ, м ³ | | Нэмэлтээр ашиглах цэвэр усны хэмжээ, м ³ | | Баримтлах стандарт |
|---|------------------------|--------|-------------------------------------|-------|--|--------|---|--------|---|-------|------------------------------------|
| | | | хоног | жил | хоног | жил | хоног | жил | хоног | жил | |
| 1 | Жонш баяжуулах үйлдвэр | 3 тонн | 556.0 | 52000 | 1944.4 | 182000 | 1512.74 | 144300 | 431.66 | 40040 | А/301 дугаар тушаалын 2-р хавсралт |

Ахуйн хэрэгцээний тооцоо

Нэг хүний хоногийн ахуйн хэрэгцээний ус 150 л байх ба энэ нь усны хэрэглээний хамгийн их байх үеийн тооцоо болно.

Уурхайн хотхонд нэг дор байрлах ажилчдын тоо нь уурхайн үйлдвэрийн ажилчид болон удирдах албан тушаалтанууд нийтдээ 88 хүн байрлан ажиллахаар тусгасан. Ахуйн хэрэглээний хоногийн усны хэмжээ нийт 13.2 м³ байх тооцоотой байна.

Хүснэгт 7. Ахуйн хэрэглээний усны тооцоо

| № | Үзүүлэлт | Хоногийн усны хэрэглээ, м ³ | Жилийн усны хэрэглээ, м ³ | Усны эх үүвсэр, ундарга |
|---|--|---|---|-------------------------------|
| 1 | Унд, ахуйн хэрэглээний ус, хоногт 20 л/хүн | 13.2 | 3564.0 | 2.0 л/с /гүний худаг/ |
| - | Нийт дүн | 13.2 | 3564.0 | - |

1.6.1. Баяжуулах үйлдвэрийн лаборатори

Баяжуулах үйлдвэрийн дэргэд хяналт, шинжилгээний лаборатори байрлана. Хяналтын лаборатори нь баяжуулах үйлдвэрт уурхайнуудаас ирж буй хүдрийн агуулгийг дундажлан жигдрүүлэх зорилгоор ашигт болон хорт хольцын хэмжээг тодорхойлох, үйлдвэрлэлийн процесст хяналт тавьж хэвийн ажиллагааг хангах, технологийн зааврын дагуу үйлдвэрийн дамжлагуудын үйл ажиллагааг хянах, үйлдвэрийн технологийн дээжийг шинжлэх, бүтээгдэхүүний чанарт иж бүрэн шинжилгээ судалгаа хийх зорилготой.

Анхдагч хүдэр, баяжмал ба хаягдлаас 6 цаг тутамд дээж аван ашигт эрдсийн болон хорт хольцын агуулгыг тодорхойлно. Шаардлагатай тохиолдолд хуваариас гадна тухай бүрт нь шинжилгээ хийж үйлдвэрийн доголдлыг илрүүлж тохиргоо хийн технологийг удирдан тогтвортой үйл ажиллагааг явуулна.

Мөн анхдагч хүдэр, баяжмал болон хаягдал хүдрийн технологийн болон химийн шинж чанарыг судалж, үйлдвэрлэлийн технологийг шинэчилж өөрчлөхөд удирдамж болгохын тулд тогтмол хугацаагаар үйлдвэрлэлийн бүх горим, дамжлагад химийн шинжилгээ хийж дүгнэлт гаргана. Үйлдвэрийн технологийн эргэлтийн усыг ээлж бүр нэг удаа тогтмол шалгаж, усанд агуулагдах элементүүдийг зөвшөөрөгдөх стандартын дагуу мөрдөн, хянаж ажиллана. Үүнээс гадна процессийн дамжлага бүр дээрх үзүүлэлтийг хянаж ажилласнаар үүсэж болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлж баяжуулах үйлдвэрийн сул зогсолтыг бууруулна.

Хяналтын лаборатори нь аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн дүрэм журмуудыг хангаж ажиллахаас гадна ХАЛМ (Хор аюулын лавлах материал) болон САЖ (Стандарт ажлын журам)-ийг мөрдөн дараах ажлыг гүйцэтгэнэ.

Дээж бэлтгэл

Флотацийн туршилт

Ширхэглэлийн шинжилгээ

Баяжмал, хаягдлын чийглэг, хатуу шингэний харьцааг тодорхойлох

Нунтаглалтын хугацааг тодорхойлох

Химийн шинжилгээ – CaF₂, CaCO₃, SiO₂, S, P₂, O₂ ба бусад элементүүдийг ээлжийн лаборантууд 24 цагт шинжилгээ хийж үзүүлэлтүүдээ тодорхойлно.

Хүснэгт 8. Лабораторийн тоног төхөөрөмжүүдийн жагсаалт

| № | Төхөөрөмжийн нэр | Марк | Хүчин чадал |
|----|--|---------------|------------------------------------|
| 1 | Аналитик жин | FA2104A | 0.0001-160 гр |
| 2 | Техник жин | BFW 150 | 150 кг хүртэл |
| 3 | Бөмбөлөгт жижиг тээрэм | HF серийн | - |
| 4 | РН метр | PHS-25 | РН-0-14 |
| 5 | Микроскоп | TXS102-01A | томруулалт 100х-1250х |
| 6 | Ус нэрэгч | HS.Z11.5 | 5 литр |
| 7 | Центрифуги | TGL-165 | 16500 эрг/мин 12x1.5/2ml |
| 8 | Хатаах шүүгээ | DZ 6050MBE | |
| 9 | Шатаах зуух | ST-1200RX | Ажлын температур 11000 С |
| 10 | Лабораторийн ширээ | JTM-S13 | |
| 11 | Термометр | H-9283 | |
| 12 | Хуваагч | TX | Хуваах хэмжээ 1.25-13 мм |
| 13 | Спектрометр | 722G | Долгионы уртын хязгаар 325-1000 nm |
| 14 | Лабораторийн жижиг багаж, шил сав, бусад | - | - |
| 15 | Хацарт бутлуур, булт бутлуурын комплекс | HF серийн | - |
| 16 | Вентилятор | - | - |
| 17 | Хөрс, ус, агаарын бохирдлыг хянах шинжилгээний багаж | - | - |
| 18 | Бусад тоног төхөөрөмж, багаж | - | - |

Лаборатори нь дээж шинжилгээнд бутлан бэлтгэх тоног төхөөрөмжүүдээс гадна аналитик жин, хатаах шүүгээ, шатаах зуух, калориметр, стандарт шигшүүр, химийн шилэн савууд зэрэг техник тоног төхөөрөмж бүрэн тоноглогдоно. Лабораторит CaF₂, CaCO₃, SO₂, SO₃, Pг, O₂, S ба бусад элементүүдийг ээлжийн лаборантууд 24 цагт шинжилгээ хийж үзүүлэлтүүдээ тодорхойлно.

Баяжуулах үйлдвэрийн химийн лабораторит флюоритын баяжмал, товарын бүтээгдэхүүн гаргаж авах технологийн процессод хяналт тавьж экспресс шинжилгээ хийх. Технологийн процессод хэрэглэх урвалын шинж чанарт хяналт тавих ажлуудыг дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

Мөн лабораторийн хэрэглээнд дараахи химийн бодисуудыг ашиглана. Химийн бодисуудын нэршил болон хэрэглээг хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 9. Баяжуулах үйлдвэрийн химийн лабораторт ашиглагдах химийн бодисын нэршил ба хэрэглээ

| Химийн томьёо | Олон улсын нэршил | Монгол нэршил | Савалга, мл, гр | Нийт хэрэглэгдэх хэмжээ, ш |
|--|-------------------------------|---|-----------------|----------------------------|
| HCl | Hydrochloric acid | Давсны хүчил | 500ml | 300 |
| H ₂ SO ₄ | Sulfuric acid | Хүхрийн хүчин | 500ml | 6 |
| C ₂ H ₆ O | Ethyl alcohol absolute | Хуурай этанол | 500ml | 120 |
| C ₆ H ₁₅ NO ₃ | Trolamineб. TEA | Триетаноламин | 500ml | 60 |
| CH ₃ COOH | Aceticacid | Цууны хүчил | 500g | 60 |
| H ₃ BO ₃ | Orthoboric acid | Боорын хүчил | 500g | 180 |
| KOH | Potassium hydroxide | Калийн гидроксид | 500g | 300 |
| C ₂ H ₈ N ₂ | Ethylenediamine | Этиленеидионин | 500g | 30 |
| HF | Hydrofluoric acid | Уусмалын хүчил /плавиковач кислота/ | 500ml | 30 |
| C ₆ H ₈ O ₆ | Vitamin C, Ascorbic acid | Аскорбины хүчил | 25g | 12 |
| HOH ₃ C | Hydroxylamine hydrochloride | Гидроксиламин гидрохлорид | 25g | 12 |
| C ₃₀ H ₂₆ N ₂ O ₁₃ | Calcein | Кальциен | 5g | 60 |
| C ₂₈ H ₃₀ O ₄ | Thymolphthalein | Тимолфталейн | 25 | 30 |
| KI | Potassium iodide | Калийн иодид | 100g | 2 |
| KIO ₃ | Potassium iodate | Калийн иодат | 100g | 2 |
| (C ₆ H ₁₀ O ₅) _n | Amylum | Цардуул | 500g | 2 |
| HBr | Hydrobromic acid | Гидробромийн хүчил | 500ml | 6 |
| HClO ₄ | Perchloric acid | Перхлорын хүчил | 500ml | 6 |
| NaCl | sodium chloride | Хуурай натрийн хлорид /безводный хлорид натрия/ | 500g | 12 |
| H ₈ MoN ₂ O ₄ | Ammonium molybdate | Аммонийн молибдат | 500g | 2 |
| K ₂ SO ₄ | Potassium sulphate | Хуурай калийн сульфат /безводный сульфат калия/ | 500g | 3 |
| KH ₂ PO ₄ | Potassium phosphate monobasic | Калийн дигидрофосфат | 100g | 2 |

Лаборатори нь үйлдвэрт тэжээх анхдагч хүдрийн шинж чанараас эхлээд бүхий л шат дамжлагуудад шаардлагатай үед шинжилгээ судалгаа туршилт явуулан хяналт тавьж, үйлдвэрийн технологийн процессыг сайжруулж гарц, металл авалт, агуулга зэргийг

хамгийн өндөр байлгах зорилт тавин ажиллах ба технологийн горимыг хянан тохируулна.

Лабораторид хийгдэх үндсэн ажил, хяналт

Лаборатори нь үйлдвэрт тэжээх анхдагч хүдрийн шинж чанараас эхлээд бүхий л шат дамжлагуудад шаардлагатай үед шинжилгээ судалгаа туршилт явуулан хяналт тавьж, үйлдвэрийн технологийн процессыг сайжруулж гарц, металл авалт, агуулга зэргийг хамгийн өндөр байлгах зорилт тавин ажиллах ба технологийн горимыг хянан тохируулна.

Технологийн горимын мөрдөлтөөр:

Анхдагч хүдрийн агуулга, шинж чанар хорт хольц
Флотацийн пульпын температур, зарцуулалт
Баяжмал бүтээгдэхүүний чанарын хяналт
Тээрэмд нунтаглагдсан хүдрийн ширхгийн хэмжээ Урвалж бодисын чанар
Эргэлтийн усны шинж чанар найрлага
Хаягдал хүдрийг хянах

Баяжуулалтын технологийн дамжлага бэлэн бүтээгдэхүүн баяжмалын чанарт байнгын хяналт тавих дараахи стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана.

Лабораторийн мөрдөж ажиллах стандартууд

Лабораторийн шинжилгээний дээж авах ба түүнийг бэлтгэх. MCS 2205-83
Химийн шинжилгээний аргад тавих ерөнхий шаардлага. MCS 2699-86
Хайлуур жонш. Чийгийн агуулгыг тодорхойлох арга. MHS 2700-86
Хайлуур жонш. Гуравч ислийг тодорхойлох арга. MHS 2704-86
Хайлуур жонш. Төмрийн агуулгыг тодорхойлох арга. MHS 2705-86
Хайлуур жонш. Сульфид хүдрийн агуулгыг тодорхойлох арга. MMS 2703-86
Хайлуур жонш. Хүхрийн нийт хэмжээг тодорхойлох арга. MMS 2706-86
Хайлуур жонш дахь нүүрсхүчлийн калыди болон фосфорт кальцийг тодорхойлох арга. MHS 4928-2000
Хайлуур жоншны баяжмал, окатыш болон брикет дэх нүүрсхүчлийн калыди, фосфорт кальци, цахиурын хоёрч исэл, фосфор болон нийт хүхрийг тодорхойлох арга. MHS 4929- 2000
Хайлуур жоншны баяжмалын техникийн шаардлага . MHS 145-2003

Байгаль хамгаалах тайлангийн агуулга

Төслийн хэрэгжүүлэх үе шат бүрт гарах гол болон сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагавраас урьдчилан сэргийлэх, түүнийг багасгах, нөхөн сэргээх замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх арга зам, зөвлөмж зэргийг багтаасан болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулсан аргачлал

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамруулан авч үзлээ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчныг хамгаалах хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-уудыг, Байгаль орчны Сайдын тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачилсан заавар”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ” зэргийг удирдлага болгон ажилладаг.

ХОЁР: ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ

Хөрс

Өнгөн хөрс хуулах, карьер нээх, овоолго хийх, хүдэр олборлох, тээвэрлэх, ангилан ялгах үйл ажиллагаагаар хөрс эвдэрч бохирдохоос гадна шатах, тослох материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч болзошгүй. Бохирдлын эх үүсвэр нь түлш шатахууны агуулах, бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис (угаалгын нунтаг, саван, шампунь) зэрэг болно. Уурхайд ажиллагсад, ойр орчинд байгаа хүн, мал, бичил амьтан, ургамал амьтан зэрэг нь нөлөөлөлд өртөх объект болно. Байгаль орчинд бохирдол үүссэн тохиолдолд бохирдол нь ургамал, хөрсөөр дамжин хүрээгээ тэлэх магадлалтай. Эвдэрсэн газар, хөрсийг стандарт MNS 5917:2008-ын дагуу нөхөн сэргээнэ.

Хөрсийг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материал ил задгай асгахыг хориглоно. (БОЯ, ЭХЯ-ны сайдын 1989.06.22-ны 68/А/61 дугаарын тушаал). Газар ашиглалтын бүртгэл мэдээг хөтөлж, холбогдох байгууллагад орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт заасан хугацаанд тайлагнана.

Агаар орчны бохирдол:

Хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас элдэв гаж үнэр гарах, тоосжилт, утаа тортог, CO, SO₂, NO₂-ын хэмжээ ихэсч болзошгүй.

Агаарын бохирдол нь ордод ажиллагсад, ойр орчимд буй хүн, мал, амьтан, ус, ургамал, хөрсөнд нөлөөлж болзошгүй.

Эрүүл ахуйн хяналтын ерөнхий байцаагчийн тушаалаар батлагдсан “Хот суурингийн агаар дахь хорт бодисын агууламжийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг” (Улсын ариун цэврийн байцаагчийн 1989 оны 11 тоот тушаалын 2-р хавсаргалтаар) баримтална.

Усны бохирдол:

Далд уурхайн ашиглалтын түвшинд гүний ус илрээгүй бөгөөд уурхайн болон баяжуулах үйлдвэрийн технологийн болон ундны усны хэрэгцээг хангах зорилгоор 3 ширхэг гүний худаг гаргасан ба худгийн паспортыг хавсаргав. Үйлдвэрийн хаягдал ус хаягдал усны даланд хуримтлагдах ба гүний болон гадаргын усанд сөрөг нөлөөгүй.

Бохирдлын эх үүсвэр нь бохирдсон ус, жорлон, бохирын цэг, шатах, тослох материал, машин тэрэг угаах, ахуйн бохир ус зэрэг болно. Дээрх эх үүсвэрүүд нь гадаргын болон

газар доорх усыг шууд ба шууд бусаар бохирдуулах, горимд өөрчлөлт оруулах магадлалтай. Ус бохирдоход ордод ажиллагсад, ойр хавийн хүн, мал, ан амьтан өртөх эрсдэлтэй. Ундны усны чанарын УСТ900-92 стандарт, гадаргын болон газар доорх усны ариун цэврийн хамгаалалтын бүсийн дүрэм, журмыг баримтална. Гадаргын болон газар доорх усны шинжилгээг орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу хийлгэж байх болно.

Ургамлын бүрхэвчийн бохирдол

Бохирдолын эх үүсвэр нь авто хөсөг болон бусад өөрөө явагч машин механизм дураараа зорчих, шатах тослох материал ил задгай асгаснаас үүсэх бохирдол нь ургамлын бүрхэвчийг бохирдуулах гол шалтгаан тул хамгаалалтын бүсийн дүрэм журам боловсруулж ажиллах шаардлагатай.

Ан амьтан:

Уурхайн эдэлбэр газрын орчимд амьтны аймгийн хувьд туурайтнаас цагаан зээр, махчин амьтадаас чоно, үнэг, хярс, мануул мэрэгчдээс хулгана, үхэр огодой, бозлог, туулай, алаг даахай, жигүүртнээс тас, бор бүргэд, сар, шонхор, элээ, хэрээ, харцага, тагтаа, ногтруу, болжмор, хэвлээр явагчдаас могой, хонин гүрвэл, мэлхий зэрэг ан амьтад оршино. Эдгээр амьтад нь автотехникийн дураараа зорчих болон хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас болж /хориотой үе болон зөвшөөрөлгүй ан амьтан агнаж устгах/ дайжих, устгах аюултай тул ан агнуурын тухай хуулийн заалтуудыг нарийн мөрдөж ажиллах шаардлагатай.

Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Нийт зардал /мян.төг/ | Гүйцэтгэл |
|--|---|-----------------------|---|
| 1. Агаарын чанар | | | |
| 1.1 | Агаарын чанар хэмжих эрх бүхий байгууллагаар хэмжүүлнэ. . | 500 | Хэнтий аймгийн ус цаг уурын шинжилгээний төвд |
| | Нийт зардал /мян.төг/ | 500 | |
| 2. Газрын гадарга, газар доорх усан орчин | | | |
| 2.1 | Уурхайн дотор болон уурхайн ойр орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх (урьдчилан сэргийлэх арга хэмжээнд) | Дотоод зардлаар | Хэнтий аймгийн ус цаг уурын шинжилгээний төвд болон Хаан лабд |
| 2.2 | Усны шинжилгээ хийлгэнэ. 2 удаа | 500 | |
| | Нийт зардал /мян.төг/ | 500 | |

| 3. Хөрсөн орчин | | | |
|---------------------------------------|---|-----------------|---|
| 3.1 | Хатуу хог хаягдал ахуйн химийн бодисыг эмх цэгцтэй хадгалах | Дотоод зардлаар | Хэнтий аймгийн ус цаг уурын шинжилгээний төвд болон Хаан лабд |
| 3.2 | Техникийн засвар үйлчилгээг тусгай талбайд явуулах | Дотоод зардлаар | |
| 3.3 | Хөрсний шинжилгээг ОХШ хөтөлбөрт заасны дагуу хийлгэсэн. 2 удаа | 500 | |
| 3.4 | Тээвэрлэлтийн зам болон уурхайн тоосжилтыг хаягдалын сангаас саарал ус ашиглан чийгшүүлнэ. | Дотоод зардлаар | |
| | Нийт зардал /мян.төг/ | 500 | |
| 4. Ургамлан нөмрөг | | | |
| 4.1 | Уурхайн олборлолтын талбайгаас гадна. Баяжуулах үйлдвэрийн орчинд тохижуулах ажил хийнэ.Бут, Сөөг тарих | 1500 | Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч, хяналтын инженер |
| | Нийт зардал /мян.төг/ | 1500 | |
| 5. Байгаль орчны менежментийн асуудал | | | |
| 5.1 | Болзошгүй аюулын үед орон нутгийн онцгой байдлын газартай хамтран ажиллах | Дотоод зардлаар | Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч, хяналтын инженер |
| 5.2 | Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж сургалт явуулах | 500 | |
| 5.3 | Уурхайн үйл ажиллагааны талаар оршин суугчидад илтгэл тавина. | 500 | |
| | Нийт зардал /мян.төг/ | 1000 | |
| | Бүгд зардал /мян.төг/ | 5500 | |

Хоёр. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны явцад өртөж байгаа талбайн нөхөн сэргээлтийг Үйлдвэрийн хаалт үед хийх буюу уурхайн хаалтын төлөвлөгөөнд багтаана. 2022 онд Биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 1.5 сая төгрөгийн зардлаар 300 мод тарисан. (Хавсралт Зураг Шар хуайс 100 ш, Голт бор 100 ш, Хайлаас 100 ш). Нийт зардал 2 сая төгрөг.

Тэрбум Мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Бор-Өндөр сумаас зохион байгуулсан хөдөлгөөнд тусгайлан бэлдсэн талбайд 5 настай амьдрах чадвар өндөртэй 1.5 сая төгрөгөөр худалдан авсан 50 модны суулгацыг 2022 оны 5 сард тарисан. Зөвхөн мод

газарт суулгаад орхилгүй модыг байнга усалж, тордож ургуулах хүнийг 6-10 сард нийт 4 сая төгрөгөөр цалинжуулж, мод ургах нөхцлийг бүрдүүлсэн. Нийт зардал 6 сая төгрөг.

Тэрбум Мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Си эм кэй ай ХХК-ний ажилчдын хүрээнд мод тарих аян зохион байгуулж, компаний ажилчин албан хаагчдыг өөрсдийн гэр бүл болон амьдарх орчиндоо тариж ургуулах 200 модыг 2 сая төгрөгөөр худалдан авч тарааж өгсөн.

